



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2023.04.03 № 7/640

танай _____-ны № _____-т

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Х.УРТНАСАН ТАНАА

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтын дагуу дээд газартаа тайлагнадаг, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг хяналтад аваагүйн улмаас аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн тайлангийн маягтын дагуу тухайн үед нь тайланг гаргаж явуулдаг, бүртгэл байхгүй, хяналтад аваагүй.

2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтыг нарийвчлан тусгаагүй ерөнхий агуулгаар нь оруулсан. Хүрэх түвшин аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрэх түвшинтэй нийцээгүй.

Байгууллагын мэргэжилтнүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөг загварын дагуу зөв хийсэн боловч байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг задлалгүй шууд хуулж тавьсан байна.

Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт бүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын "Аргачлал, загвар батлах тухай" 2020 оны 100 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан. Албан тушаалын тодорхойлолт дээр заасан зарим заалтуудыг өөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй албан хаагчид байна.

Байгууллагын үйлчилгээний стандартын дагуу бүгд энгэрийн тэмдэг ажлын хувцастай байсан боловч өрөө тасалгааны эмх цэгц хангалтгүй байна.

Зөвлөмж:

1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн холбогдох заалтуудыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 10.7-д заасны дагуу хяналтад авч, жил бүр жагсаалтыг шинэчлэн агентлагийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах (үйл ажиллагаа нь тогтмолжсон хэрэгжилтийг нь хангадаг хууль тогтоомж, тогтоол шийдвэрээ хяналтдаа авах)

231060129

2.

2. Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийг хэрэгжүүлж, ажиллах (сумдаас хагас, бүтэн жилээр тайланг авч дүн шинжилгээ хийж, дүгнэж байх)

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хариуцах эзэнг тодорхой болгож, холбогдох мэргэжилтнүүд хариуцсан ажлаа бүгдийг албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах бөгөөд өөрийн хийх арга хэмжээ болгон задалж оруулах

4. Шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, хүрэх түвшинг суурь түвшинтэй уялдуулах (өмнөх оны суурь түвшинг авч байх)

5. Байгууллага болон хариуцсан мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сайдтай байгуулсан гэрээний 3.33, 3.35, 3.43, 3.49, 3.50 дахь зорилтуудыг нарийвчлан оруулах

6. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд “Алсын хараа-2050” сургалт болон “Хос бичигтэн болох” гэсэн 2 арга хэмжээг тусгах.

7. Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолыг уншиж танилцах

8. Ажлын байрандаа эмх цэгцтэй зөвхөн ажилд ашиглах зүйлсээ ойр байлгаж, илүүц зүйлсийг цэгцлэх

9. Байгууллагын үйлчилгээний стандартыг чанд мөрдөх

10. Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмыг шинэчлэн баталсан. Шинээр томилогдсон албан хаагчид үүний дагуу хувийн хэргийг бүрдүүлэх

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

